



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/275

Номгон

Мал бүртгэлжүүлэх аян зохион байгуулах
тухай


Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/72 тоот тушаалын 1 дүгээр тушаалаар баталсан “Мал бүртгэлжүүлэлтийн аяныг зохион байгуулах ажлын удирдамж”-ын 9 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын үржүүлэг, технологийн ажлыг хэрэгжүүлэх хавар, намрын технологийн хугацаанд “Мал бүртгэлжүүлэлтийн аян”-ыг зохион байгуулсугай.

2.Мал бүртгэлжүүлэлтийн аяны удирдамжийг 1 дүгээр, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2 дугаар, бүртгэлжүүлэх малын төрөл, тоо хэмжээг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Аяны хүрээнд бүртгэлжүүлэхээр тогтоосноос доошгүй мал сүргийг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэхийг сумын Засаг дарга нарт, нэгдсэн удирдлагаар ханган, ажлын тайлан, мэдээг нэгтгэн танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ж.Баттөр/-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Т.Хишигбаатар/-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010695

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 26 ны өдрийн А/З-75-дугаар захирамжийн 1 дүгээр хөвдөрлөлт.



МАЛ БҮРТГЭЛЖҮҮЛЭЛТИЙН АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг.Зорилго

Мал бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн санд баяжилт хийх, хяналт тавих зорилгоор аймгийн хэмжээнд тэмээ, үхэр, хонь, ямаа нийт 18969 толгой малыг хувийн дугаартай болгон бүртгэлжүүлж, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, мал бүртгэлжүүлэлтийн ажлын үр дүн, ач холбогдолыг олон нийтэд сурталчлан таниулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Аймгийн Хөдөө аж ахуйн газар, сумын Хөдөө аж ахуйн тасаг, Мал үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний нэгж, малчид, мал аж ахуй эрхлэгчид,

Гурав. Хугацаа

Хаврын мал үржүүлэг технологит хугацаа буюу 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 20-ныг хүртэл,

Намрын мал үржүүлэг технологит хугацаа буюу 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 20-ныг хүртэл 2 үе шаттай хэрэгжүүлнэ.

Дөрөв.Аяны хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

1.Улсын төсвийн санхүүжилтээр үзлэг ангилалт хийх баталгаажсан үүлдэр, омгийн малын цөм сүрэг болох 12373 малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

2.Цөм, үржлийн сүргийн болон шинээр нөхөн тавьсан өсвөр бог малын хээлтүүлэгчийг бүрэн ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэн үржлийн бүртгэл хөтөлж, малын үндэсний бүртгэл мэдээллийн санд оруулсан байна.

3. Сумын төв, суурин газарт сүүний чиглэлээр үржүүлж байгаа үхрийг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэн, мэдээллийн нэгдсэн санд оруулна.

4.Мал бүртгэлжүүлэлтийн аяны нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлын ач холбогдлыг /шторк/ олон нийтийн мэдээллийн сувгаар сурталчлах ажлыг зохион байгуулна.

5.Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж болон мал эмнэлгийн хувийн аж ахуйн нэгжүүдийн хамтын

2.

ажиллагааг сайжруулж, оролцоог жигд хангах, гэрээт ажлыг гүйцэтгүүлэх талаар сумын хөдөө аж ахуйн тасагт чиглэл хүргүүлнэ.

6. Аяныг орон нутагт зохион байгуулахад сумын шийдвэр гарган, нэгдсэн зохион байгуулалттай ажиллах талаар мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

7. Зах зээлд худалдан борлуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах малд хямд үнэтэй чанарын шаардлага хангасан ээмгийг захиалгын дагуу нийлүүлэх ажлыг судлан хэрэгжүүлнэ.

8. Ялган тэмдэглэсэн малыг удам зүйн үнэлгээнд хамруулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

9. Аяны нэгдсэн дүнг гаргаж, санал дүгнэлтийг байгууллагын хуралд хэлэлцүүлэн, дээд шатны байгууллагад танилцуулна.

Тав. Аяны хүрээнд хийгдсэн ажлын үр дүнг тооцох

1. Төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг гаргасан байна.

2. Ээмэглэж, бүртгэлжүүлсэн малын мэдээллийг малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүрэн оруулсан байна.


3. Мал бүртгэлжүүлэлтийн ажлын үр дүнг зохион байгуулсан талаар сумын ажлыг дүгнэн танилцуулга бэлтгэсэн байна.

Зургаа. Санхүүжилт

Олон улсын төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, бүх шатны мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд санхүүжилтийг шийдвэрлэсэн байна

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 26-ны
 өдрийн А/275 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт




**МАЛЫГ ЯЛГАН ТЭМДЭГЛЭЖ, БҮРТГЭЛЖҮҮЛЭХ ТАЛААР 2021 ОНД
 ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4	5
1	Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлын төлөвлөгөө, аяны удирдамжийг боловсруулан батлуулах, орон нутагт хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах	3-6 дугаар сар	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Сумын Засаг даргын тамгын газар
2	Аймгийн хэмжээнд ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх малын судалгаа гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулах	3-11 дүгээр сар	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Сумын хөдөө аж ахуйн тасаг, Малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж
3	Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программын сургалтанд хамрагдах	4-5 дугаар сар	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Сумын хөдөө аж ахуйн тасаг,
4	Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн хөгжүүлэлтийг хийх, нэвтрүүлэх	4-11 дүгээр сар	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Сумын хөдөө аж ахуйн тасаг, Малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж
5	Мал сүргийг вакцинжуулах хавар, намрын технологит хугацаанд мал эмнэлгийн газартай хамтран ажиллах талаар санал солилцох	4-5 дугаар сар	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Мал эмнэлгийн газар
6	Малыг ялган тэмдэглэх судалгааг үндэслэн хэрэглэх багаж хэрэгсэл, шаардагдах хүн, хүч, техник хэрэгсэл, мал баригчийн тооцоо судалгааг гаргах	4 дүгээр сар	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Сумын хөдөө аж ахуйн тасаг, Малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж

1	2	3	4	5
7	Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлын шторкийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацаж сурталчлах	4, 6, 8, 10 дугаар сар	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	ХХААГ-ын захиргаа, аж ахуйн алба
8	Мал бүртгэлжүүлэх аяныг эхлүүлэх асуудлаар сумын холбогдох албан тушаалтнуудад цахим хурал зохион байгуулах	4-5 дугаар сар	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Сумын Засаг даргын тамгын газар
9	Засаг захиргааны нэгжийн код, малын дугаар бүхий ээмгийг сумдын захиалгын дагуу хийлгэн, хүргүүлэх	4-11 дүгээр сар	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Сумын хөдөө аж ахуйн тасаг,
10	Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх, малын үндэсний бүртгэл мэдээллийн санд мэдээллийг оруулах ажлыг зохион байгуулах	Жилдээ	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Сумын хөдөө аж ахуйн тасаг, Малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж
11	Үзлэг ангилалтанд хамрагдсан цөм сүргийн малд удам зүйн үнэлгээ хийх	Жилдээ	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Сумын хөдөө аж ахуйн тасаг,
12	Хавар намрын технолоит хугацаанд малыг ялган тэмдэглэж, бүртгэсэн бүртгэлд анализ, шинжилгээ хийх	11 дүгээр сард	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Сумын хөдөө аж ахуйн тасаг,
13	Хавар намрын технологит хугацаанд малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлсэн ажлын аяны тайлан мэдээг гаргаж, дүгнэх	12 дугаар сар	Хүнс, хөдөө аж ахуй газар, Мал үржлийн алба	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Сумын Засаг даргын тамгын газар

Амгын засаг даргын 04 дугаар сарын 26-ны өдөр /2021/ дугаар захирамжын 3 дугаар хэсэрт



МАЛ БҮРТЭЛЖҮҮЛЭЛИЙН АНХНЫ ХҮРЭЭНД ЯЛГАН ТЭМДЭГЛЭХ МАЛЫН ТӨРӨЛ, ТОО ХАМЖАЭ

№	Сумын нэр	Баталгажсан үүлдэр, омгийн төм сүрэг бүрдүүлэн ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх малын тоо						Ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх Хил залгаа сумдын бод малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх тоо						Нийт дүн							
		Бүгд	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа
1	Баянхонгор	0					100	0	0	0	100	0	0	0	0	50	50	0	0	0	100
2	Баацагаан	0					100	0	0	0	100	0	0	0	0	50	50	0	0	0	100
3	Баянбулаг	3200					3200	0	0	0	3350	0	0	0	0	50	3300	50	0	0	3350
4	Баянговь	0					400	0	0	0	400	0	0	0	0	150	250	0	0	0	400
5	Баянлиг	505	505				0	0	0	0	505	505	0	0	0	0	0	0	0	0	505
6	Баян-Овоо	0					180	0	0	0	180	0	0	0	0	100	80	0	0	0	180
7	Баян-Өндөр	2120					359	2120			2599	100	20	0	159	2320	120	20	0	0	2479
8	Баянцагаан	0					560				560	0	0	0	240	320	0	0	0	0	560
9	Борд	305	305				0				305	305	0	0	0	0	305	0	0	0	0
10	Бөмбөгөр	2120					805	2120			2925	0	0	0	321	2604	0	0	0	0	2925
11	Буцгаан	0					150				150	0	0	0	75	75	0	0	0	0	150
12	Галуут	500					600				1100	0	0	0	300	300	500	0	0	0	600
13	Гурванбулаг	0					60				60	0	0	0	30	30	0	0	0	0	60
14	Жаргалант	503					557		503		1060	0	0	0	819	241	0	0	0	0	1060
15	Жинст	0					270				270	0	0	0	90	180	0	0	0	0	270
16	Зар	0					286				286	0	0	0	118	168	0	0	0	0	286
17	Өлзийт	500					220		500		720	0	0	0	100	120	500	0	0	0	220
18	Хүрээмарал	0					778				778	0	0	0	382	396	0	0	0	0	778
19	Шинэжинст	2120					221	2120			2621	250	30	95	2246	280	200	200	200	95	2341
20	Эрдэнэцогт	500					400				900	0	0	0	200	200	500	0	0	0	400
	Дүн	12373	810	1500	3703	6360	6196	0	0	2876	3320	400	350	50	18969	1160	1550	6579	9680	2710	16259